



МОНГОЛ УЛСЫН  
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ТУШААЛ

2017 оны 02 сарын 24 өдөр

Дугаар А/76

Улаанбаатар хот

Гэмтэл, согог судлалын үндэсний төвийн  
дүрэм, бүтцийг батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.4 дэх заалт, Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.4, 21 дүгээр зүйлийн 21.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Гэмтэл, согог судлалын үндэсний төвийн дүрмийг нэгдүгээр, бүтцийг хоёрдугаар хавсралтаар тус тус шинэчлэн баталсугай.
2. Батлагдсан дүрэм, бүтцийг үйл ажиллагаандаа мөрдлөг болгож ажиллахыг Гэмтэл, согог судлалын үндэсний төв /Т.Мөнхсайхан/-д үүрэг болгосугай.
3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга /Д.Очирбат/-д үүрэг болгосугай.
4. Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан Эрүүл мэндийн сайдын 2013 оны 390 дугаар тушаалыг хүчингүй болгосугай.

САЙД

А.ЦОГЦЭЦЭГ



080256

Эрүүл мэндийн сайдын  
2017 оны 02 сарын 24-ны өдрийн  
11 дугаар тушаалын 1 дүгээр  
хавсралт

## ГЭМТЭЛ, СОГОГ СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ДҮРЭМ

### Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Гэмтэл, согог судлалын үндэсний төв (цаашид төв гэнэ) нь Монгол Улсын хэмжээнд гэмтэл, согог судлалын чиглэлээр лавлагаа шатлалын эмнэлгийн мэргэшсэн тусламж, үйлчилгээ үзүүлэх, эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах сургалтыг зохион байгуулах, эрдэм шинжилгээ, судалгааны ажил эрхлэх, тухайн чиглэлээр улсын хэмжээнд бусад эрүүл мэндийн байгууллагуудыг мэргэжил арга зүйн удирдлагаар хангах чиг үүрэг бүхий төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг мөн.

1.2. Төв нь Монгол Улсын Үндсэн хууль, Эрүүл мэндийн тухай хууль, Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Иргэний хууль, Хөдөлмөрийн тухай болон бусад холбогдох хууль тогтоомжийн хүрээнд үйл ажиллагаа явуулна.

1.3. Төвийн оноосон нэр нь "Гэмтэл, согог судлалын үндэсний төв" байх батовчилсон нэр нь "GCCYT", оршин байгаа газар нь Монгол Улс, Улаанбаатар хот 16094, Баянгол дүүрэг, 7 дугаар хороо, Чингүнжавын гудамж-4 хаягт байрлана.

1.4. Төвийн нэрийг англи хэлээр "National Center For Traumatology And Orthopedics" гэнэ.

1.5. Энэ дүрмийн зорилго нь төвийн үйл ажиллагааны үндсэн чиг үүргийг тодорхойлж, удирдлага, зохион байгуулалтын бүтцийг тогтоон хяналт тавих, эд хөрөнгийн эрх, түүнээс үүсэх бусад харилцааг зохицуулахад оршино. Энэхүү дүрэм нь Төвийн эрх зүйн байдал, үйл ажиллагааны чиглэл, удирдлага, санхүүжилттэй холбогдсон нийтлэг харилцааг зохицуулах баримт бичиг мөн.

1.6. Төв нь тамга, тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудас, санхүүгийн харлцах данс, өөрийн бэлэгдэлтэй байна.

1.7. Энэ дүрмийн 1.6-д заасан тамга, тэмдгээр төвийн албан ёсны шийдвэр, албан, гэрээ, хэлцлийг тамга тэмдгээр баталгаажуулна. Төвийн ерөнхий захирлын томилсон албан тушаалтан тамга, тэмдгийг түшнэ.

### Хоёр. Төвийн үндсэн зорилго, түүний эрх, үүрэг

#### 2.1. Төвийн алсын хараа

Гэмтэл, согог судлалын чиглэлээр сургалт, эрдэм шинжилгээ, эмнэлгийн мэргэшсэн тусламж, үйлчилгээ үзүүлэх мэргэжлийн өндөр чадавхийг бүрдүүлж, үйл ажиллагаандын чанарын цогц удирдлагыг нэвтрүүлэн, осол гэмтлээс

сэргийлэх үйл ажиллагааг эрчимжүүлэх, эмнэлгийн тусlamж, үйлчилгээний чанарыг тасралтгүй сайжруулах замаар олон улсын түвшинд өрсөлдөх чадвар бүхий үндэсний хэмжээний төв болно.

## **2.2. Төвийн эрхэм зорилго**

Үйлчүүлэгчдийн эрэлт, хэрэгцээнд нийцсэн, чанар, аюулгүй байдлыг хангасан гэмтэл, согог судлалын эмнэлгийн мэргэшсэн тусlamж, үйлчилгээг шуурхай, чирэгдэлгүй үзүүлэхэд оршино.

## **2.3. Төвийн зорилго**

Анагаах ухааны орчин үеийн дэвшилтэй технологийг үе шаттай нэвтрүүлж, гэмтэл бэртэл, согогийг оношлох, эмчлэх, сувилах, хөнгөвчлөх, сэргээн засах цогц үйл ажиллагааг олон улсын стандартад нийцүүлэн өрсөлдөхүйц хэмжээнд хүргэх, өндөр ур чадвартай хүний нөөцийг хөгжүүлж, тусlamж, үйлчилгээг тэгш, шударга, хүртээмжтэй, чанартай үзүүлнэ.

## **2.4. Төвийн үйл ажиллагааны зарчим**

- 2.4.1. Үйлчлүүлэгчдийг дээдлэх, тэгш хандах, чирэгдэлгүй, шуурхай үйлчлэх;
- 2.4.2. Хүний эрх ашиг, нэр төрийг хүндэтгэн, нууцыг нь чанд хадгалах;
- 2.4.3. Эрүүл мэндийн тусlamж, үйлчилгээг чанартай, аюулгүй үзүүлэх;
- 2.4.4. Шийдвэр бүрийг нотолгоонд суурилан гаргах;
- 2.4.5. Ил тод, нээлттэй байх;
- 2.4.6. Ёс зүйн хэм хэмжээг чанд сахих.

## **2.5. Төвийн эрх**

2.5.1. Гэмтэл, согог судлалын чиглэлээр улсын хэмжээнд мөрдөгдөх хууль, дүрэм, стандарт, эмнэлзүйн заавартай холбоотой санал боловсруулах, нотолгоонд суурилсан мэргэжлийн дүгнэлт гаргаж, эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад санал тавьж шийдвэрлүүлэх;

2.5.2. Гэмтэл, согог судлалын чиглэлээр байгууллага, аж ахуйн нэгж, иргэдэд мэргэжлийн зөвлөмж, зааварчилгаа өгөх, шаардлага тавих;

2.5.3. Дотоод, гадаадын иргэд байгууллага болон олон улсын байгууллагатай гэрээ хэлэлцээр байгуулах, хамтран ажиллах, хөтөлбөр, төсөл боловсруулах, хэрэгжүүлэх;

2.5.4. Дотоод, гадаадын болон олон улсын шинжлэх ухааны байгууллага, их, дээд сургууль, нийгэмлэг, холбоонд гишүүнээр элсэх тэдгээрийн үйл ажиллагаанд оролцох;

2.5.5. Эрдмийн зөвлөлийг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн байгуулах, эмнэлзүйн судалгаа шинжилгээ хийх, төгсөлтийн дараах сургалт зохион байгуулах;

2.5.6. Батлагдсан төсөв, орон тоо, байгаа нөөц бололцоонд тулгуурлан санхүүжилтийг зориулалтын дагуу захирсан зарцуулах, холбогдох тушаал, журмын дагуу зарим тусlamж, үйлчилгээг төлбөртэй үзүүлэх;

2.5.7. Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн орон тооны бус зөвлөл, мэргэжил ур, чадварын түвшин тогтоох комисс, өмч хөрөнгө хамгаалах, эмнэлгийн

санхүүжилтийг үр дүнтэй удирдах, түүний зарцуулалтад хяналт тавих комисс, ажлын хэсэг байгуулан ажиллуулах;

2.5.8.Байгууллагын ажилтныг шагналд тодорхойлох, холбогдох дээд шатны байгууллагад санал тавьж, шийдвэрлүүлэх;

2.5.9.Үйл ажиллагааны ил тод байдлыг хангах, үйлчлүүлэгчдэд эмнэлгийн тусlamж, үйлчилгээний зохион байгуулалт, мэдээ мэдээллийг түгээх зорилгоор цахим хуудас, мэдээний сан зэрэг олон нийтийн мэдээллийн сүлжээтэй байх;

2.5.10.Үндсэн чиг үүрэг, эрхлэх асуудлын хүрээнд ном, гарын авлага, эмхэтгэл гаргах, олон нийтийн мэдээллийн хэрэгслээр мэдээлэл, зөвлөмж өгөх;

2.5.11.Эрүүл мэндийн тухай хууль, тогтоомж болон бусад холбогдох хууль тогтоомжоор олгосон бусад эрх.

## 2.6.Төвийн үүрэг

2.6.1.Төв нь “Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлого”-ыг хэрэгжүүлэх, салбарын хөгжлийн бодлоготой уялдуулан байгууллагын хөгжлийн дунд хугацааны төлөвлөлтийг хийж, баталгаажуулан хэрэгжүүлэх;

2.6.2.Төвийн зорилго, үндсэн чиг үүргийн хүрээнд хууль, тогтоомж, сайдын тушаалыг хэрэгжүүлэх, эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон эрүүл мэндийн бусад байгууллагуудын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх;

2.6.3.Гэмтэл, согог судлалын төрөлжсөн мэргэшлээр улсын хэмжээнд эмнэлгийн лавлагаа шатлалын тусlamж, үйлчилгээ үзүүлэх, оношилгоо, эмчилгээний зөвлөмж, дүгнэлт гаргах;

2.6.4.Гэмтэл, согог судлалын төрөлжсөн мэргэшлээр улсын хэмжээнд мэргэжил, арга зүйгээр хангах чиг үүргийг хэрэгжүүлэх, оношилгоо, эмчилгээний стандарт, эмнэлзүйн заавар, аргачлал боловсруулах, бусад эрүүл мэндийн байгууллагыг мэргэжил арга зүйн удирдлагаар хангах;

2.6.5.Гэмтэл, согог судлалын тусlamж, үйлчилгээг сайжруулах, салбарын хэмжээнд тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх арга хэмжээний санал боловсруулан эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тавьж шийдвэрлүүлэх;

2.6.6.Гэмтэл, согог судлалын тусlamж, үйлчилгээний чиглэлээр эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын шийдвэрийн дагуу эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах сургалт явуулах, бусад эрүүл мэндийн байгууллагад мэргэжлийн баг ажиллуулах, ажлын байрны болон алсын зайн сургалт явуулах;

2.6.7.Гэмтэл, согог судлалын тусlamж, үйлчилгээний чанарыг сайжруулах, аюулгүй байдлыг хангах, иргэний эх орондоо оношлуулж, эмчлүүлэх нөхцлийг хангах, эмчилгээний үр дүнг сайжруулах чиглэлээр олон улсын жишигт нийцсэн нотолгоонд суурилсан, зардлын үр ашиг бүхий оношлогоо, эмчилгээний дэвшилтэт технологийг нэвтрүүлэх;

- 2.6.8. Осол, гэмтлийн шалтгаант хүн амын өвчлөлийн түвшин, тархалт, нас барагтыг судлах тандалтын тогтолцоог бий болгон мэдээний сан бүрдүүлж, төрийн захирагааны төв байгууллага болон холбогдох бусад байгууллагыг мэдээллээр хангах;
- 2.6.9. Хувь хүн, гэр бүл, хамт олонд осол гэмтэл, хүчирхийллээс сэргийлэх, бууруулах чиглэлээр мэдлэг олгох, албан бус сургалт зохион байгуулах, бусад төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран ажиллах;
- 2.6.10. Ажиллагсдын мэдлэг, мэргэжлийн ур чадвар, сахилга хариуцлагыг сайжруулах, эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээг мөрдүүлэх арга хэмжээг тогтмол хэрэгжүүлэх;
- 2.6.11. Ажиллагсдын нийгмийн баталгааг хангах, ажлын байрны нөхцөлийг сайжруулах арга хэмжээг тогтмол авч хэрэгжүүлэх;
- 2.6.12. Гэмтэл, согог судлалын оношилгоо, эмчилгээний технологийг сайжруулах чиглэлээр өндөр хөгжилтэй орнууд, олон улсын байгууллагуудтай гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэх, туршлага судлах, шинэ дэвшилтэй технологийг нэвтрүүлэх;
- 2.6.13. Төв нь өөрийн чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардагдах төсвийг үндэслэл тооцоо судалгаанд тулгуурлан боловсруулах, батлагдсан төсөв, орон тооны хязгаарт багтааж, төвийн үйл ажиллагааг зохион байгуулах;
- 2.6.14. Барилга байгууламж, эмнэлгийн тоног төхөөрөмж, техник, хэрэгслийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн талаар холбогдох стандартын шаардлагыг ханган ажиллах ;
- 2.6.15. Үндсэн болон төсөвт хөрөнгийн ашиглалтын зарцуулалт, нягтлан бодох бүртгэл, тасаг, алба, нэгжийн аж ахуйн тооцоо, байгууллагын орлого зарлагын дотоодын хяналт шалгалтыг тогтмолжуулах;
- 2.6.16. Төрийн өмчийн эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хангаж тайлан, эд хөрөнгийн бүртгэл тооллогыг тогтоосон хугацаанд хийх, данснаас хасах, шилжүүлэх, устгал хийх асуудлыг Төрийн өмчийн хороонд тавьж шийдвэрлүүлэх;
- 2.6.17. Эрүүл мэндийн тухай хууль тогтоомж болон бусад холбогдох хууль тогтоомжоор хүлээлгэсэн бусад үүрэг.

### **Гурав. Төвийн удирдлага, түүний эрх, үүрэг**

- 3.1. Төвийн удирдлагын тогтолцоо нь Ерөнхий захирал, дэд захирал, Удирдлагын зөвлөлөөс бүрдэнэ.
- 3.2. Төвийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулах эрхийг Ерөнхий захирал хэрэгжүүлж, тушаал гаргана.
- 3.3. Төвийн дэд захирал өөрийн хариуцсан чиг үүргийг Ерөнхий захирлын удирдлага дор гүйцэтгэж, тайлагнана.

3.4.Удирдлагын зөвлөл нь байгууллагын хөгжил, зохион байгуулалт, өдөр тутмын удирдлагын үйл ажиллагааны асуудлаар Ерөнхий захиралд зөвлөх чиг үүргийг гүйцэтгэнэ. Удирдлагын зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг Ерөнхий захирлын тушаалаар батална.

3.5.Удирдлагын зөвлөл нь төлөвлөгөөт болон шуурхай хэлбэрээр хуралдаж, олонхийн саналаар хурлын шийдвэр гаргана.

3.6.Төвийн эрдэм шинжилгээ судалгаа, эрүүл мэндийн технологийн үнэлгээ хийх, оношилгоо, эмчилгээний дэвшилтэт технологийг нэвтрүүлэх, мэргэжлийн үйл ажиллагаанд үнэлгээ дүгнэлт өгөх, зөвлөх эрх бүхий Эрдмийн зөвлөл ажиллуулж болно. Эрдмийн зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг холбогдох хууль тогтоомж, тушаал шийдвэрт нийцүүлэн Ерөнхий захирлын тушаалаар батална.

3.7.Төв нь эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагаас гаргасан тушаал, шийдвэрийн дагуу эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн салбар хороо, эмийн эмчилгээг зохицуулах хороо, бусад шаардлагатай хороо, зөвлөлийг байгуулан ажиллуулна.

3.8.Төвийн зохион байгуулалтын бүтцийн нэгж нь тасаг, алба байна. Зохион байгуулалтын бүтцийн нэгжийн удирдлага нь тухайн тасаг, албаны өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулж, ажилтантай хөдөлмөрийн болон үр дүнгийн гэрээ байгуулан ажиллана.

### **3.9. Ерөнхий захирлын эрх, үүрэг**

3.9.1.Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнтэй байгуулсан Хөдөлмөрийн болон Үр дүнгийн гэрээний үндсэн дээр үйл ажиллагаа явуулж, Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний өмнө ажлаа хариуцан тайлагнах;

3.9.2.Төвийн хүний нөөцийн бодлогыг тодорхойлж, батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төвийн тасаг, албадын орон тоо, ажиллагсдын цалин хөлсийг тогтоох;

3.9.3.Тасаг, албадын хэрэгжүүлэх чиг үүргийг тогтоох, дэд захирал болон ажиллагсдын ажлын байрны тодорхойлолтыг батлах, ажилтныг ажилд томилох, хөдөлмөрийн гэрээ байгуулах, хууль тогтоомжийн хүрээнд ажлаас халах, чөлөөлөх, хөдөлмөрийн гэрээг дуусгавар болгох, цуцлах;

3.9.4.Ажилтныг гадаад, дотоодод томилолтоор ажиллуулах, захиргааны чөлөө олгох, ажлын үр дүнг үндэслэн шагнаж, урамшуулах, хариуцлага хүлээлгэх;

3.9.5.Төвийн хэмжээнд мөрдөх журам, заавар, тушаалыг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн баталж, мөрдүүлэх;

3.9.6.Төвийг гадаад, дотоодод бүрэн хэмжээгээр төлөөлөх;

3.9.7.Төсвийн ерөнхийлөн захирагчтай жил бүр үр дүнгийн гэрээ байгуулан биелэлтийг ханган ажиллах, төсөв хөрөнгийг үр дүнтэй, зориулалтын дагуу захиран зарцуулах;

3.9.8.Ажилтныг мэдлэг, боловсрол, ур чадварыг дээшлүүлэх сургалтанд хамруулах, цалин хөлс, нийгмийн баталгааны асуудлаар гаргасан санал, хүсэлтийг холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэх;

3.9.9.Ажилтны талаар гаргасан өргөдөл, гомдлыг дангаараа буюу холбогдох эрх бүхий байгууллагатай хамтран шийдвэрлэх;

3.9.10.Ерөнхий захирал шаардлагатай тохиолдолд өөрийн эрх, үүргийг итгэмжлэлийн үндсэн дээр холбогдох албан тушаалтанд түр шилжүүлж болно. Ийнхүү эрхээ шилжүүлсэн нь түүнийг хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй.

**3.10.Эмнэлгийн тусlamж, үйлчилгээ хариуцсан дэд захирлын чиг үүрэг**

3.10.1.Төвийн захирлын тушаалаар батлагдсан өөрийн ажлын байрны чиг үүргийг гүйцэтгэх ба ерөнхий захирлын эзгүйд орлон ажиллах;

3.10.2.Эмнэлгийн тусlamж, үйлчилгээний асуудлыг хариуцан эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас батласан оношилгоо, эмчилгээ, тусlamж, үйлчилгээний журам, заавар, стандартыг төвийн хэмжээнд мөрдүүлэх;

3.10.3.Төвийн яаралтай тусlamжийн үйл ажиллагааг оновчтой зохион байгуулж, орон нутгийн эрүүл мэндийн байгууллагаас ирүүлсэн алсын дуудлага, зөвлөх баг ажиллуулах ажлыг удирдан зохион байгуулах;

3.10.4.Холбогдох хууль тогтоомжийн хүрээнд бусад эрүүл мэндийн байгууллагуудыг мэргэжил арга зүйн удирдлагаар хангах, алсын зайн сургалт, зөвлөгөөг удирдан зохион байгуулах;

3.10.5.Эмнэлгийн тусlamж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг сайжруулах, эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээг мөрдүүлэх ажлыг удирдан зохион байгуулах;

3.10.6.Зөвлөх эмч, эмч, тасгийн эрхлэгч, сувилагч нарын өдөр тутмын эмчилгээ, үйлчилгээтэй холбоотой асуудлыг зохицуулах, ажил үүргийн хуваарийг батлуулан ажиллах;

3.10.7.Төвийн хэмжээнд оношилгоо, эмчилгээнд олон улсын жишигт нийцэхүйц, дэвшилтэт технологийг нэвтрүүлэх ажлыг хариуцан зохион байгуулах;

**3.11.Эдийн засаг, төлөвлөлт, хүний нөөц хариуцсан дэд захирлын чиг үүрэг**

3.11.1.Байгууллагын болон хүний нөөцийн хөгжил, бодлого, төлөвлөлт, эрүүл мэндийн даатгал, төсөв санхүүжилт, бүртгэл, мэдээллийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулах;

3.11.2.Төвийн төсөв санхүүжилт, нягтлан бодох бүртгэл, болон бусад санхүүгийн асуудлыг Ерөнхий захиралд тухай бүр танилцуулан, шийдвэрлүүлэх;

3.11.3.Эрүүл мэндийн даатгал, санхүү, бүртгэлийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулж, санхүүгийн сахилга батыг сахиулах, батлагдсан төсвийн дагуу хөрөнгийг үр ашигтай, хэмнэлттэй зарцуулах үйл ажиллагааг холбогдох хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлэх;

3.11.4.Үйлчилгээний төлбөр, эрүүл мэндийн даатгалтай холбоотой иргэдийн санал гомдолыг шуурхай шийдвэрлэж, “Шилэн дансны тухай” хуулийн хэрэгжилтэд хяналт тавих;

3.11.5.Эрүүл мэндийн салбарын бодлого, хөтөлбөртэй нийцүүлэн байгууллагын дунд хугацааны төлөвлөгөө, хөтөлбөр, төсөл, жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулах ажлыг зохион байгуулах;

3.11.6.Хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулан, эмнэлгийн мэргэжилтний тасралтгүй сургалтын үйл ажиллагааг удирдан зохион байгуулах;

3.11.7.Эрдэм шинжилгээ, судалгаа болон гадаад хамтын ажиллагааны төсөл, хөтөлбөрийг салбарын хөгжлийн бодлого, төлөвлөлттэй нийцүүлэн боловсруулах, хэрэгжүүлэх үйл ажиллагааг удирдан зохион байгуулах;

### **3.12.Мэдээллийн технологи, хангамж, үйлчилгээ хариуцсан дэд захирлын чиг үүрэг**

3.12.1.Эмнэлгийн тусlamж, үйлчилгээг үзүүлэхэд шаардлагатай хангамж, үйлчилгээ, технологийн нөхцлийг бүрдүүлэх үйл ажиллагааг удирдан зохион байгуулах;

3.12.2.Байгууллагын цахим технологийг салбарын мэдээллийн технологийн бодлого хөтөлбөртэй уялдуулан хөгжүүлэх асуудлыг удирдан зохион байгуулах;

3.12.3.Эмнэлгийн тоног төхөөрөмжийн ашиглалт, аюулгүй ажиллагааг удирдан зохион байгуулах;

3.12.4.Ажиллагсдын ажиллах нөхцөл, үйлчилгээгээр хангах, төсвийн санхүүжилтийг аль болох хэмнэлттэй, үр ашигтай ашиглах, зарцуулах, хангамж, үйлчилгээний ажлыг удирдан зохион байгуулах;

3.12.5.Байгууллагын өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, зарцуулалтанд хяналт тавьж, ажиллах;

3.12.6.Байгууллагын халдвартын сэргийлэлт, хяналт, эрүүл ахуйн үйл ажиллагааг удирдан зохион байгуулах;

3.12.7.Байгууллагын үйлчилгээний соёлыг сайжруулах, захиргаа, хангамж үйлчилгээний ажлын гүйцэтгэлд хяналт тавих;


### **Дөрөв. Гадаад, дотоод хамтын ажиллагаа**

4.1.Төвийн Ерөнхий захирлын гадаад улсад туршлага судлах, мэргэжлийн сургалтад суралцах, хурал, семинарт оролцох албан томилолтыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний тушаалаар шийдвэрлэнэ.

4.2.Төв нь төрийн захиргааны төв байгууллагын удирдлага, газрын дарга нартай шууд харилцаж, эрүүл мэндийн талаарх төрийн бодлого, хууль тогтоомжийг биелүүлэх ажлыг зохион байгуулахдаа чиглэл, үүрэг зөвлөмж авч үйл ажиллагаагаа уялдуулан ажиллана.

4.3.Төв нь өөрийн эрхлэх асуудлаар бусад эрүүл мэндийн байгууллага, төрийн ба төрийн бус байгууллага, иргэдтэй холбогдох хууль тогтоомжийн хүрээнд хамtran ажиллана.

**Тав. Төвийн гэмтэл, согог судлалын төрөлжсөн мэргэшлээр  
улсын хэмжээнд мэргэжил, арга зүйгээр хангах  
чиг үүргийг хэрэгжүүлэх хүрээ**



## **Зургаа. Санхүүжилт, хөрөнгийн зарцуулалт**

### **6.1. Төвийн санхүүжилт нь дараах эх үүсвэрээс бүрдэнэ:**

- 6.1.1. Улсын төсөв;
- 6.1.2. Эрүүл мэндийн даатгал;
- 6.1.3. Үндсэн үйл ажиллагааны орлого /төлбөртэй тусlamж, үйлчилгээ/;
- 6.1.4. Туслах үйл ажиллагааны орлого;
- 6.1.6. Гадаадын зээл, тусlamж, төсөл, хөтөлбөрийн санхүүжилт;
- 6.1.7. Бусад эх үүсвэр

6.2. Төв нь санхүүжилт, эд хөрөнгийг төвийн үндсэн зорилго, холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн зориулалтын дагуу зарцуулж, ашиглана.

6.3. Төв нь өөрийн эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хангаж, үндсэн хөрөнгө олж авах, тэдгээрийг данснаас хасах, шилжүүлэх, актлах саналаа холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлүүлнэ.

6.4. Төвийн эд хөрөнгийн тооллогыг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиар тогтоосон хугацаанд, холбогдох журмын дагуу явуулна.

6.5. Төв нь нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг Монгол Улсын Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Олон улсын нягтлан бодох бүртгэлийн стандартын дагуу гүйцэтгэж, аудит хийлгэнэ. Аудиторыг гэрээний үндсэн дээр сонгож ажиллуулна.

6.6. Төв нь өөрийн эд хөрөнгө, санхүү, нягтлан бодох бүртгэл, тооцоонд тавих өөрийн болон хөндлөнгийн хяналтыг зохих хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлнэ.

### **Долоо. Төвийн зохион байгуулалтын бүтцийн нэгж, түүний өрөнхий чиг үүрэг**

#### **7.1. Чанар, дотоод хяналтын алба**

Төвийн урт, дунд хугацааны хөгжлийн төлөвлөлт, хөтөлбөр, жилийн үйл ажиллагааны төлөвлөгөө, тусlamж, үйлчилгээний чанар, аюулгүй байдалд хяналт тавих ажлыг зохион байгуулна.

#### **7.2. Яаралтай тусlamжийн нэгдсэн тасаг**

Яаралтай тусlamжийг нэгдсэн байдлаар шуурхай үзүүлэх зорилгоор хүлээн авах яаралтай тусlamжийн тасаг, дурс оношилгооны тасаг, мэс заслын нэгдсэн тасаг, лаборатори, цус сэлбэлтийн албаны үйл ажиллагааг нэгтгэн зохион байгуулж, 24 цагийн тасралтгүй үйлчилгээг үзүүлнэ.

#### **7.3. Хүлээн авах, яаралтай тусlamжийн тасаг**

Улсын хэмжээнд гэмтэл, согогийн чиглэлээр хүлээн авах, яаралтай тусlamж, үйлчилгээг үзүүлнэ.

#### **7.4. Дурс оношилгооны тасаг**

Бүх төрлийн гэмтэл, согогийн рентген, хэт авиа, компьютерт томограф, уян дурангийн оношилгоо хийж, дурс оношилгооны дэвшилтэт арга, технологийг нэвтрүүлнэ.

## **7.5.Мэс заслын нэгдсэн тасаг**

Төлөвлөгөөт болон яаралтай мэс заслын бэлтгэл, халдварт хамгаалал, аюулгүй байдал, хагалгааны багаж төхөөрөмжийн болон мэс заслын хэвийн үйл ажиллагааг хангах, мэс заслын дараах сэрээх, хянах, шилжүүлэх үйлчилгээг үзүүлнэ.

## **7.6.Лабораторийн тасаг**

Лабораторийн ерөнхий болон иммунологи, серологи, бактериологи, амьд ахуйн эд эсийн шинжилгээ хийж, онош баталгаажуулах, эмчилгээний үр дүнг хянахад шаардлагатай нотолгоо, дүгнэлтийг гаргана.

## **7.7.Цус сэлбэлтийн алба**

Цус, цусан бүтээгдэхүүнийг тээвэрлэх, хадгалах, сэлбэх, аюулгүй ажиллагааг хангана. Аюулгүй ажиллагааны аргачлалд эмнэлгийн мэргэжилтнийг сургах, цус, цусан бүтээгдэхүүн сэлбэсэнтэй холбоотой урвал, хүндрэлийг зохих журмын дагуу бүртгэх, мэдээлэх, сэргийлэх ажлыг зохион байгуулна.

## **7.8.Амбулаторийн тасаг**

Гэмтэл, согогийн чиглэлээр амбулаторийн лавлагаа тусламж, үйлчилгээ үзүүлж, санал, хүсэлтийг хүлээн авч, иргэдэд лавлагаа мэдээллээр шуурхай, чирэгдэлгүй хангах үйл ажиллагааг зохион байгуулна.

## **7.9.Сэргээн засах эмчилгээний тасаг**

Гэмтлийн дараах эд эрхтэний үйл ажиллагааг сэргээн засах эмчилгээ үйлчилгээ үзүүлнэ. Уламжлалт анагаах ухааны эмч, мэргэжилтнүүдийг ажиллуулж монгол эм танг, орчин үеийн эмчилгээтэй хослуулан эмчилгээнд хэрэглэнэ.

## **7.10.Хэвтүүлэн эмчлэх тасгууд**

Түлэнхий, нөхөн сэргээх, гавал тархи, цээж, хэвлий, гар сарвуу, хүзүү, нуруу нугас, яс үений гэмтэл болон үений эмгэгийн мэс заслын тасаг, хүүхдийн гэмтэл, согогийн тасаг, эрчимт эмчилгээ, мэдээгүйжүүлгийн тасагт хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээг үзүүлнэ. Хэвтэн эмчлүүлэх тасгуудын дэргэд эмгэг судлалын хэсэг ажиллуулж, шүүх эмнэлэгтэй хамтран ажиллах, цогцост задлан шинжилгээ хийх бэлтгэл хангах, оношийн зөрүүг тодорхойлох, эмгэг судлалын хурал хийх зэрэг чиг үүргийг хэрэгжүүлнэ.

## **7.11.Эм зүйн алба**

Эм зүйн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг хангаж, эмчилгээний өндөр идэвхитэй, чанарын баталгаатай, аюулгүй, эдийн засгийн үр ашигтай эм, эмнэлгийн хэрэгслээр тасралтгүй хангах, эмийн жор бичилт, зохистой хэрэглээг төлөвшүүлэх, эмийн гаж нөлөөг бүртгэн мэдээлэх, нян эмэнд тэсвэржихээс урьдчилан сэргийлэх, эмч мэргэжилтнүүдийг эмийн мэдээллээр хангах үйл ажиллагааг зохион байгуулна.

## **7.12.Сувилахуйн алба**

Төвийн хэмжээнд сувилахуйн тусламж, үйлчилгээг зохион байгуулж, сувилахуйн тусламж, үйлчилгээний чанарын хөгжлийн төлөвлөгөө, хөтөлбөр, стандартын хэрэгжилтийг хангах, хянах, заавар зөвлөгөө өгөх, сувилахуйн тусламж үйлчилгээний чанар, аюулгүй байдал, халдварт хамгаалал, сэргийлэлт, хөдөлмөрийн аюулгүй ажиллагаанд хяналт тавих, чанарыг тасралтгүй сайжруулах талаар санал, зөвлөмж боловсруулан арга зүйгээр хангаж ажиллана.

### **7.13. Нийгмийн эрүүл мэндийн алба**

Осол, гэмтлээс сэргийлэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх, осол гэмтэл, хүчирхийлэлд хүргэж байгаа нийгэм, эдийн засгийн эрсдэлт хүчин зүйлсийг судлах, урьдчилан сэргийлэх бууруулах зөвлөмж, боловсруулах, бусад салбартай хамтран ажиллах, хүчирхийлэлд өртөгсдөд эрүүл мэндийн болон сэтгэлзүйн нэг цэгийн үйлчилгээг үзүүлнэ.

### **7.14. Эдийн засаг, санхүү, бүртгэлийн алба**

Төвийн үйл ажиллагаанд шаардлагатай санхүүжилтийг бодитой тодорхойлох, байгууллагын хэмжээнд хөрөнгө оруулалтын арга хэмжээ, төсвийн төслийг боловсруулах, эрүүл мэндийн даатгал, санхүүгийн бүртгэл, мэдээллийн үйл ажиллагааг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн хэрэгжүүлнэ.

### **7.15. Төлөвлөлт, гадаад харилцааны алба**

Төвийн хөгжлийн дунд хугацааны болон жилийн үйл ажиллагаан төлөвлөгөөг боловсруулж, гадаад хамтын ажиллагааны гэрээ хэлцэл хийх, төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг зохион байгуулна.

### **7.16. Хүний нөөцийн хөгжлийн алба**

Хүний нөөцийн хөгжлийн төлөвлөлтийг хийх, түүний хэрэгжилтийг зохион байгуулах, ажиллагсдыг тогтвортой суурьшилтай ажиллах нөхцөлөөр хангах, эмнэлгийн мэргэжилтний ёс зүй, мэдлэг, мэргэжлийг тасралтгүй дээшлүүлж, ажлын байран дахь сургалтыг зохион байгуулна.

### **7.17. Эрдэм шинжилгээ, судалгааны алба**

Гэмтэл, согог судлалын чиглэлээр судалгаа, шинжилгээний ажил эрхэлж, оношилгоо эмчилгээний шинэ технологийг нэвтрүүлэх чиглэлээр төсөл боловсруулах, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулна.

### **7.18. Статистик, бүртгэл, тандалт судалгааны алба**

Төвийн статистик мэдээ, мэдээллийг цуглуулах, бүртгэх, нэгтгэх, мэдээлэх, дамжуулах, тайлгахаа, мэдээний сан үүсгэх үйл ажиллагааг хариуцна. Осол, гэмтлийн шалтгаант өвчлөлийн шалтгаан, тархалтыг судалж, тандалт судалгааны чиглэлээр бусад эрүүл мэндийн байгууллагуудад мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлнэ.

### **7.19. Мэдээллийн технологийн алба**

Төвийн үйл ажиллагаанд мэдээллийн технологийн дэвшлийг нэвтрүүлэн цахим эмнэлэг, цахим бүртгэл, цахим өвчний түүхийг ашиглах, орон нутгийн эрүүл мэндийн байгууллагуудад алсын зайн мэргэжлийн зөвлөгөө, сургалт явуулахад шаардлагатай техникийн нөхцөлөөр хангах мэдээллийн технологийг үйл ажиллагааг зохион байгуулна.

### **7.20. Эмнэлгийн тоног, төхөөрөмжийн алба**

Эмнэлгийн тоног төхөөрөмжийн хэвийн үйл ажиллагааг хангаж, тоног төхөөрөмжийн ашиглалт, аюулгүй ажиллагааны журмыг мөрдүүлж, засвар үйлчилгээг зохион байгуулна.

### **7.21. Инженер, техникийн алба**

Төвийн барилга, цахилгаан, ус, дулаан хангамж, эд хогшил, автомашины хэвийн үйл ажиллагааг хангах, засвар үйлчилгээг хийх ажлыг зохион байгуулна.

## **7.22.Халдварын хяналт, сэргийлэлтийн алба**

Халдварын хяналт, сэргийлэлт, халдвартгүйтгэлийн үйл ажиллагааг зохион байгуулна.

## **7.23.Хангамж, үйлчилгээний алба**

Гадаад болон дотоод орчны тохижилтыг хийж, байгууллагын харуул хамгаалалт, аюулгүй байдлыг хангана. Байгууллагын цэвэрлэгээ, үйлчилгээний ажлыг нэгдсэн зохион байгуулалтанд оруулан үйлчилгээний соёлыг сайжруулан ажиллана.

### **Найм. Бусад зүйл**

8.1.Энэхүү дүрэмд тусгагдсанаас бусад асуудлыг холбогдох хууль тогтоомж, эрх зүйн баримт бичгээр зохицуулна.

--оОо---

Эрүүл мэндийн сайдын  
2017 оны 42 сарын 14-ны өдрийн  
176 дугаар тушаалын 2 дугаар  
хавсралт

## ГЭМТЭЛ, СОГОГ СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН БҮТЭЦ

